



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

**Үл хөдлөх хөрөнгө төрийн өмчид бүртгэх,
төрийн байгууллагад эзэмшүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 11 дүгээр зүйлийн 1, 2, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналтын улсын ахлах байцаагчийн 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 4186 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо, Бөхийн өргөөний хойд талд байрлах 441 м.кв талбайтай, Монгол Улсын түүх, соёлын дурсгал болох Анхны холбооны барилгыг төрийн өмчид бүртгэж, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт эзэмшүүлсүгэй.

2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Ч.Чинбат)-т даалгах нь:

2.1. Анхны холбооны барилга нь Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болохын хувьд бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын болон түүх, соёлын дурсгалт цогцолбор газрын бүсийг тогтоолгох асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;

2.2. Барилгыг хувийн хэвшлийн дэлгүүр, зоогийн газруудаас чөлөөлүүлж, "Ванхүү" ХХК-иас албан ёсоор хүлээн авах арга хэмжээ авах;

2.3. "Арвис" сургуулийн захирал (тухайн үеийн) А.Лхагва, "Ванхүү" ХХК (захирал Б.Боролзойхүү)-иас Анхны холбооны барилгын ашиглалт, хамгаалалт, сэргээн засварлалтын талаар хийсэн ажлын тайлан, өмчлөх эрхийн гэрчилгээг хууль бусаар гаргуулж, түүх соёлын дурсгалт зүйлийн хамгаалалтын бүсэд барилгад тулган олон давхар барилга бариулсан асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

2.4. Анхны холбооны барилгатай холбоотой хувийн хэвшлийн холбогдох иргэн аж ахуйн нэгжийн тайлан, тайлбар, барилга хүлээлцсэн акт, хүлээн авах үеийн чанар, бүрэн бүтэн байдлын талаарх танилцуулгыг 2020 оны 4 дүгээр сард багтаан Хуралдаанд танилцуулах;

2.5. Соёлын өвийн тухай хуульд нийцүүлэн Анхны холбооны байшингийн анхны гадаад төрх байдлыг өөрчлөлгүйгээр хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангах, сэргээн засварлах, зориулалтын дагуу ашиглах арга хэмжээ авах;

2.6. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу санхүүгийн тайлагналын зориулалтаар үнэлүүлж, нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.7. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ